



БАТЛАВ:  
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИГЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

.....  
Я.ТӨМӨРБААТАР



**ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ФИЗИКИЙН ЛАБОРАТОРИЙН  
ТАВИЛГА, ЭД ХОГШИЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/гэрээний нэр: ШУС-ийн физикийн лабораторын тавилга, эд хогшил нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер

Дугаар: МУИС/202004020

2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Монгол Улсын Их Сургууль** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос ШУС-ийн физикийн лабораторийн тавилга, эд хогшил нийлүүлэх-ийг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр** ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 10 цаг 40 минутанд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Үгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо,  
МУИС-ийн оюутны 5-р байр 06 тоот,  
Зохион байгуулагч Ц.Батсүрэн  
Холбоо барих утас: 75754400- /1213/**

Хоёр.

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
  - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (a) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

**7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.


7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.





**8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>• <i>Үнийн санал маягтын дагуу ирүүлэх,</i></li> <li>• <i>Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулан маягтын дагуу ирүүлэх,</i></li> <li>• <i>Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх,</i></li> <li>• <i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг ирүүлэх,</i></li> <li>• <i>Нийгмийн даатгалын ерөнхий газрын тодорхойлолт ирүүлэх,</i></li> <li>• <i>Нийлүүлэх барааны зураг, танилцуулгын хамт ирүүлэх,</i></li> <li>• <i>Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mta.mn">www.e-tax.mta.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй, өргүй байна,</i></li> <li>• <i>2018,2019 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайланг ирүүлнэ,</i></li> <li>• <i>Түргэн хөрвөх хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 100%-иас багагүй байна,</i></li> <li>• <i>2018, 2019 он тус бүр хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын мэдээлэл /хийсэн ажлын гэрээ, актыг ирүүлэх/,</i></li> <li>• <i>2018 ,2019 он тус бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй дүнтэй тэнцүү, түүнээс багагүй байна,</i></li> <li>• <i>Барааны чанарын баталгаат хугацаанд /12 сар/ засварлах, сэлбэх үйлчилгээ үзүүлэх тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл,</i></li> <li>• <i>Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч буй мэдэгдэл ирүүлнэ,</i></li> <li>• <i>Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлэх</i></li> <li>• <i>Тендерт оролцогчийг төлөөлөх этгээдэд олгосон итгэмжлэл,</i></li> </ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Монгол Улсын Их Сургууль,</i>  <i>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</i>  Огноо: <i>2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр</i>  Цаг: <i>10 цаг 00 минут</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Монгол Улсын Их Сургууль, Оюутны 5 дугаар байр</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>1 давхар 06 тоот</i></p> <p>Огноо: <i>2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 40 минут</i></p>

Д/Д	Барааны нэр, төрөл	Техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Зураг
1	<p><b>Лабораторийн төвийн ширээ, шилэн бодисын тавиур</b></p>	<p><b>Зориулалт:</b> Лабораторийн төвийн шинжилгээний ширээ нь 2 талаасаа ажилладаг, тавцангийн дээр 2 давхар тавиуртай байна.</p> <p>Тавцангийн доор хоёр талдаа шинжилгээний бодис, материал, шил сав хадгалах хоёр хаалгатай шүүгээнүүд, шургуулгатай. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж чадах олон улсын стандартад тэнцсэн бүтээгдэхүүн байх ёстой.</p> <p><b>Материал:</b> Материал шүүгээ болон бусад хэсгийг өндөр шахалттай 18мм хавтангаар хийж, PVC бүрээсээр ирмэгийг хийсэн.</p> <p><b>Хэмжээ:</b> Лабораторийн төвийн ширээг 1.0 м урт, өргөн нь 1.5м өндөр нь 0.85 м байна.</p> <p><b>Тавцан:</b> Ширээний дээд талын тавцанг хүчил шүлт, органик уусгагч, химийн бодист тэсвэртэй, хар өнгөтэй хүндрүүлсэн 25 мм зузаан зориулалтын Ероху материалаар хийсэн байх.</p> <p>Өнгөний сонголт: саарал Тавиурын хэмжээ 1000*250*700мм хөнгөн цагаан рамтай</p>	4	
2	<p><b>Лабораторийн хажуугийн ширээ</b></p>	<p><b>Зориулалт:</b> Лабораторийн хажуугийн ширээ нь нэг талаасаа ажилладаг, тавцангийн дээр шилэн нүүртэй, модон бодис хадгалах хананд өлгөдөг шүүгээтэй, тавиуртай байна.</p> <p>Тавцангийн доор нэг талдаа шинжилгээний бодис, материал, шил сав хадгалах хоёр хаалгатай шүүгээнүүд, шургуулгатай. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж чадах олон улсын стандартад тэнцсэн бүтээгдэхүүн байх ёстой.</p> <p>Лабораторийн хажуугийн ширээ 1000x750x850мм хэмжээтэй</p> <p>Ажлын тавцан нь 12,7 мм-н зузаантай ба pheniloc resin хэмээх хүчтэй хүчил, шүлт, гадаргуу зурагдах, элэгдэл, гал, халуун, өндөр температурын нөлөө зэрэгт тэсвэртэй зориулалтын материалаар хийгдсэн.</p>	8	

		1000*300*600мм хэмжээтэй, өлгөдөг шилэн нүүртэй, их бие нь 18 мм зузаантай шахмал хавтан модон материалаар хийгдсэн. <b>Өнгө:</b> саарал		
3	<b>Лабораторийн сандал (түшлэгтэй)</b>	<b>Зориулалт:</b> Лабораторийн орчин нөхцөлд зохицсон, түшлэгтэй сандал <b>Өнгө:</b> Хар суудлын бүрээстэй. <b>Материал:</b> Никель төмөр хийцээр хийгдсэн, дугуйгүй, сургалтанд ашиглах бат бөх хийцтэй байх	15	
4	<b>Лабораторийн сандал (түшлэггүй)</b>	<b>Зориулалт:</b> Лабораторийн орчин нөхцөлд зохицсон. <b>Өнгө:</b> Хар суудлын бүрээстэй. <b>Материал:</b> Никель төмөр хийцээр хийгдсэн, дугуйгүй, сургалтанд ашиглах бат бөх хийцтэй байх	10	
5	<b>Лабораторийн ширээ</b>	Тавиуртай ширээ 120x65x75мм Тавиур 120*32*30мм <b>Материал:</b> Материал шүүгээ болон бусад хэсгийг өндөр шахалттай 18мм хавтангаар хийж, PVC бүрээсээр ирмэгтэй байх ёстой. <b>Өнгө:</b> Шаргал	6	
6	<b>Төмөр шкаф</b>	<b>Хэмжээ:</b> 900 мм х 400 мм х 1850 мм <b>Материал:</b> Төмөр <b>Өнгө:</b> Цайвар саарал	1	
	<b>Нийт</b>		44	

**ТАВ. БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо шир хэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8



<p><b>Лабораторийн төвийн ширээ, шилэн бодисын тавиур</b></p>	<p><b>Зориулалт:</b> Лабораторийн төвийн шинжилгээний ширээ нь 2 талаасаа ажилладаг, тавцангийн дээр 2 давхар тавиуртай байна.</p> <p>Тавцангийн доор хоёр талдаа шинжилгээний бодис, материал, шил сав хадгалах хоёр хаалгатай шүүгээнүүд, шургуулгатай. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж чадах олон улсын стандартад тэнцсэн бүтээгдэхүүн байх ёстой.</p> <p><b>Материал:</b> Материал шүүгээ болон бусад хэсгийг өндөр шахалттай 18мм хавтангаар хийж, PVC бүрээсээр ирмэгийг хийсэн.</p> <p><b>Хэмжээ:</b> Лабораторийн төвийн ширээг 1.0 м урт, өргөн нь 1.5м өндөр нь 0.85 м байна.</p> <p><b>Тавцан:</b> Ширээний дээд талын тавцанг хүчил шүлт, органик уусгагч, химийн бодист тэсвэртэй, хар өнгөтэй хүндрүүлсэн 25 мм зузаан зориулалтын Ероху материалаар хийсэн байх.</p> <p>Өнгөний сонголт: саарал Тавиурын хэмжээ 1000*250*700мм хөнгөн цагаан рамтай</p>	4	ш	Хичээлийн 1-р байр 3 давхар 311 тоот	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
---	---	---	---	--------------------------------------	-----------------------------------	----------------------------------	--

<p><b>Лабораторийн хажуугийн ширээ</b></p>	<p><b>Зориулалт:</b> Лабораторийн хажуугийн ширээ нь нэг талаасаа ажилладаг, тавцангийн дээр шилэн нүүртэй, модон бодис хадгалах хананд өлгөдөг шүүгээтэй, тавиуртай байна. Тавцангийн доор нэг талдаа шинжилгээний бодис, материал, шил сав хадгалах хоёр хаалгатай шүүгээнүүд, шургуулгатай. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж чадах олон улсын стандартад тэнцсэн бүтээгдэхүүн байх ёстой.</p> <p>Лабораторийн хажуугийн ширээ 1000x750x850мм хэмжээтэй</p> <p>Ажлын тавцан нь 12,7 мм-н зузаантай ба pheniloc resin хэмээх хүчтэй хүчил, шүлт, гадаргуу зурагдах, элэгдэл, гал, халуун, өндөр температурын нөлөө зэрэгт тэсвэртэй зориулалтын материалаар хийгдсэн.</p> <p>1000*300*600мм хэмжээтэй, өлгөдөг шилэн нүүртэй, их бие нь 18 мм зузаантай шахмал хавтан модон материалаар хийгдсэн.</p> <p><b>Өнгө:</b> саарал</p>	8	ш	Хичээлийн 1-р байр 3 давхар 311 тоот	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
<p><b>Лабораторийн сандал (түшлэгтэй)</b></p>	<p><b>Зориулалт:</b> Лабораторийн орчин нөхцөлд зохицсон, түшлэгтэй сандал</p> <p><b>Өнгө:</b> Хар суудлын бүрээстэй.</p> <p><b>Материал:</b> Никель төмөр хийцээр хийгдсэн, дугуйгүй, сургалтанд ашиглах бат бөх хийцтэй байх</p>	15	ш	Хичээлийн 1-р байр 3 давхар 311 тоот	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
<p><b>Лабораторийн сандал (түшлэггүй)</b></p>	<p><b>Зориулалт:</b> Лабораторийн орчин нөхцөлд зохицсон.</p> <p><b>Өнгө:</b> Хар суудлын бүрээстэй.</p> <p><b>Материал:</b> Никель төмөр хийцээр хийгдсэн, дугуйгүй, сургалтанд ашиглах бат бөх хийцтэй байх</p>	10	ш	Хичээлийн 1-р байр 3 давхар 311 тоот	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	

<b>Лабораторийн ширээ</b>	Тавиуртай ширээ 120x65x75 мм Тавиур 120x32x30мм <b>Материал:</b> Материал шүүгээ болон бусад хэсгийг өндөр шахалттай 18мм хавтангаар хийж, PVC бүрээсээр ирмэгтэй байх ёстой. <b>Өнгө:</b> Шаргал	6	ш	Хичээлийн 1-р байр 3 давхар 311 тоот	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
<b>Төмөр шкаф</b>	<b>Хэмжээ:</b> 900 мм x 400 мм x 1850 мм <b>Материал:</b> Төмөр <b>Өнгө:</b> Цайвар саарал	1	ш	Хичээлийн 1-р байр 3 давхар 311 тоот	Гэрээ байгуулсанаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	
		44					

Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**

**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч холбоо барих хаяг /утас/ факс	Гэрээний үнийн дүн	Гэрээ эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад				

## Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- |                                     |  |
|-------------------------------------|--|
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>            | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлууна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b> | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.   |

- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежер тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежер хүргүүлнэ.

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

**18. Гэрээг цуцлах**

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл



дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс  
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

### Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар нь: <i>ШУС- физикийн лабораторийн тавилга, эд хогшил нийлүүлэгчийг сонгон шалгаруулах, МУИС/202004020</i>
ГЕН 2.1	Ажил нь <i>тавилга, эд хогшил нийлүүлэхээс бүрдэнэ.</i> Ажлын талбай нь <i>МУИС хичээлийн 2 дугаар байр</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: <i>Гэрээ байгуулсан өдөр</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: <i>Гэрээ байгуулсанаас хойш 30 өдрийн дотор</i>
ГЕН 8.1	<i>Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад эвдэрч, гэмтэхээс урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авч ажиллах ба тээвэрлэлтээс үүссэн хохиролыг бүрэн хариуцна.</i>
ГЕН 11.1	Гүйцэтгэлийн баталгаа <i>гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна.</i>
ГЕН 12.1	Даатгалын тусгай шаардлага: <i>Даатгалын бүх нөхцөлийг гүйцэтгэгч тал хариуцна.</i>
ГЕН 13.1	Алданги оногдуулах хувь: <i>Бараа нийлүүлж дуусгахаар төлөвлөгдсөн өдрөөс хойш хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний дүнгийн 0.1 хувиар алданги тооцно.</i> Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>10 хувиас хэтрэхгүй байна.</i> Баталгаат засварын хугацаа нь: <i>Багаж тоног төхөөрөмжийг актаар хүлээн авсан өдрөөс хойш 12 сар байна.</i>
ГЕН 16	Төлбөр хийх хугацаа: <i>Барааг 100% хүлээлгэн өгсөн, хүлээн авсан акт баримт, хурлын тэмдэглэл, чанарын баталгааг байршуулсан баримт зэргийг захиалагч талд хүлээлгэн өгсөнөөс хойш ажлын 5 хоног дотор гэрээний нийт дүнтэй тэнцэх дүнг нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ.</i>
ГЕН 17.1	<i>Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг ажил хүлээлгэн өгөхдөө хамт хүргүүлнэ.</i>
	<i>Татвар, даатгалын төлбөрийг гүйцэтгэгч тал бүрэн хариуцана.</i>
Маргааныг шийдвэрлэх (ГЕН-21.0)	<i>Талуудын хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.</i> <i>Зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд хуульд заасны дагуу шүүхээр шийдвэрлэнэ.</i>

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

## Ес.ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

### ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

### **[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/  
Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

**5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
- 8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]